

**БАТЛАВ.**  
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН**  
**ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ**

  
**Б.НАРАНТУЯА**  
ААУ 456 9086331

**БАТЛАВ.**  
**МОНГОЛЫН ХҮҮХДИЙН**  
**АНАГААХЫН НИЙГЭМЛЭГИЙН**  
**ТЭРГҮҮН**

  
**Г.СОЁЛГЭРЭЛ**  
УННТ 118 383

## СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

2017 оны 12-р сарын 04-ны өдөр Дугаар ...

Улаанбаатархот

Нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид “Захиалагч” гэх/ нөгөө талаас Монголын хүүхдийн анагаахын нийгэмлэг /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Ерөнхий зүйл

1. Монгол улсын засгийн газрын 2017 оны 78 –р тогтоолоор батлагдсан “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/358 тоот тушаалын 2.2.12 дахь заалтын 3-т 18 сар, 36 сартай хүүхдэд эрүүл мэндийн цогц үзлэг хийж хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх эрх зүйг бүрдүүлнэ гэж заасантай холбогдуулан 18 сар, 36 сартай хүүхдийн цогц үзлэгийн маягтыг боловсруулан үзлэг хэрхэн хийж маягтыг хөтлөх талаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч сувилагч нарт сургалт хийх шаардлагатай байна.

2. ЭМХТ-ийн үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын байрны тасралтгүй сургалтуудын ихэнх нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх, өрх, сумын эмч сувилагчдын ажлын байрны сургалт бөгөөд эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоонд шинээр 18 сар, 36 сартай хүүхдийн цогц үзлэгийн мэдээллийг оруулахтай холбогдуулан сургагч багш бэлтгэхэд энэхүү сургалтын гэрээ чиглэнэ. Энэ гэрээ нь **Захиалагч, Гүйцэтгэгч** нарын хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.

3. Гэрээний зүйл: ЭМХТ-ийн захиалгаар 2017 оны 12-р сард явуулах “18 сар 36 сарай хүүхдийн эрүүл мэнд хөгжлийн цогц үзлэг “ хэрхэн зохион байгуулах талаар өрх сумын эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан сургагч багшийн сургалтыг зохион байгуулах.

4. Гэрээний үнэ: “18 сар 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн үзлэг хэрхэн хийх сургалтын модуль боловсруулж, сургагч багш бэлтгэх” сургалтын зардал нь / төгрөг байна.

### Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

1. Захиалагч нь сургалтын явцтай танилцах, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, сургалтын чанар, зохион байгуулалтад хяналт тавих;

2. Батлагдсан төсвийн дагуу сургалтын зардлыг гүйцэтгэгч талын нэхэмжлэлийг үндэслэн цаг хугацаанд нь шийдвэрлэж тасралтгүй байдлыг хангах. Зарцуулалтад хяналт тавих;

3. Захиалагч нь ажлын захиалга өөрчлөх, хугацаа сунгах зэрэг тохиолдолд гэрээний нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж баталгаажуулна. Нэмэлт өөрчлөлт орсон хэсгээс бусад үндсэн гэрээний нөхцөлүүд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

4. Сургалтын зохион байгуулалттай холбоотой доголдолтой зүйл гарвал Захиалагч доголдлыг арилгуулах, санал гомдлыг шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд гарсан зардлыг нөхөн төлүүлнэ.

### Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

1. Гүйцэтгэгч нь захиалагчийн хэрэгцээнд нийцсэн эмнэл зүйн сургалтын модуль, удирдамж, сургалтын материал боловсруулан, сургалтыг явуулах эрх бүхий өндөр ур чадвартай багш нараар хичээлийг удирдуулна.

2. Сургалт явуулах багийг бүрдүүлэн дараах ажлуудыг хийх:

- a. Сургалтын хөтөлбөр боловсруулах
- b. Хүүхдийн үзлэгийн маягт боловсруулна.
- c. Хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулна.

3. Сургалтыг хөтөлбөрийн дагуу чадамжид суурилсан сургалтын аргаар, батлагдсан төсөвт багтаан сургалтыг чанартай зохион байгуулна.

4. Суралцагчдын мэдлэг чадварын түвшинг сургалт эхлэхийн өмнө болон сургалтын дараа харьцуулан үр дүнг үнэлэх

5. Сургалтын цагийн 1/3-ыг өрхийн эрүүл мэндийн төв дээр хийнэ.

6. Гэрээнд заасан хугацаанд сургалт зохион байгуулагдаагүй эсвэл алдаа дутагдал гарсан тохиолдолд хугацаа хоцорсон хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн нийт дүнгийн 0,2 хувиар алданги хүлээнэ.

10. Ажил гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий зүйлийн 2-т заасан өдрүүдэд багтаан сургалтыг зохион байгуулна.

11. Сургалт зохион байгуулсан тайланг захиалагчид хүлээлгэн өгнө.

### Дөрөв. Бусад

1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба бичгээр үйлдэнэ.


3. Гэрээний явцад үүсэх аливаа маргаантай асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба харилцан тохиролцох боломжгүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

### ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
ЭМАХА-ны даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч

З.Наранбаатар

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
“Энх Ирээдүй” хүүхдийн эмнэлгийн  
эрхлэгч, анагаах ухааны доктор



Д.Даваасүрэн